



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/146.

Мандалговь

Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан
оготнотой микробиологийн аргаар
тэмцэх ажлыг зохион байгуулах

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7, 32.1.9, 32.1.10, дахь заалт, Байгалийн ургамлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, Хүнс Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/76 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үлийн цагаан оготнотой микробиологийн аргаар тэмцэх ажлыг Адаацаг, Говь-Угтаал, Дэрэн, Дэлгэрцогт, Сайнцагаан, Сайхан-Овоо, Цагаандэлгэр зэрэг нийт 7 сумын 20,0 мянган га бэлчээрийн талбайд улсын төсвийн хөрөнгөөр 2021 оны 5 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн 05 дугаар сарын 15-ний өдрийг хүртэл 14 хоногийн хугацаанд багтаан явуулсугай.

2. Тухайн ажлыг зохион байгуулахдаа Засгийн газрын 185 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн "Бэлчээр хамгаалах өдөр"-тэй холбогдуулан сум бүр орон нутагт зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, мэргэжлийн анги албад, албан байгууллага, иргэдийг оролцуулан гүйцэтгүүлж, малын бэлчээрт үр дүнтэй ажил зохион байгуулахыг холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Микробиологийн аргаар тэмцэх арга хэмжээг зохион байгуулахдаа "Коронавирус Ковид-19" цар тахлын халдвараас урьдчилан сэргийлж халдвар хамгаалал, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах, аюулгүй ажиллагааны зааварчилгааг нарийн чанд мөрдөж ажиллахыг голомт бүхий сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулан, тэмцэх талбай болон сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, гэрээний биелэлтэд хяналт тавих, тайлан мэдээг хугацаанд нь Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Мөнхжаргал, холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

.. 481210412

5. Үлийн цагаан оготной тэмцэх арга хэмжээг орон нутгийн төсөвт зардалд багтаан малчид болон ажиллах хүнийг зохион байгуулж, технологийн дагуу хугацаанд нь үр дүнтэй, чанартай гүйцэтгэх, тайлангаа хугацаанд нь ирүүлэхийг сумдын засаг дарга нарт үүрэг хариуцуулсугай.

6. Ажлын явцад байнгын хяналт тавьж, илэрсэн дутагдал, зөрчлийг цаг алдалгүй арилгаж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналт газарын дарга (Ш.Төрбат)-т үүрэг болгосугай.

7. 2021 онд бэлчээрийн хортон мэрэгч үлийн цагаан оготной тэмцэх сумдын нэр бэлчээрийн талбайн хэмжээг хавсралтаар баталсугай.

Хавсралт.....хуудастай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ